



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цэцэг сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн  
тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/005/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот

2025 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Бадрал

Аудитор: С.Оюунжаргал

Аудитор: Т.Бат-Эрдэнэ

Утас: 91983443

Цахим хаяг: badralts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт.....	1
<b>1. АУДИТЫН ДҮГНЭЛТ.....</b>	<b>2</b>
<b>2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....</b>	<b>4</b>
2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
<b>3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>9</b>
3.1 Төлбөрийн акт .....	10
3.2 Албан шаардлага .....	11
3.3 Зөвлөмж .....	12
3.3.1 Орон нутгийн хөгжлийн сантай холбоотой асуудал.....	12
3.3.2 Төрийн сан, дотоод хяналттай холбоотой асуудал .....	12
<b>4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....</b>	<b>13</b>
<b>5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл.....</b>	<b>14</b>

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан

## 1. АУДИТЫН ДҮГНЭЛТ



### ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг  
Утас/Факс: (976)-7043-3061  
Email: khovd@audit.gov.mn

2026.03.25 № 272  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ЦЭЦЭГ СУМЫН ЗАСАГ  
ДАРГА Б.БАЯРСАЙХАН ТАНАА

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Цэцэг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны улмаас Цэцэг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.7, 6.4.1, 6.5.5, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 15 дугаар зүйлийн 15.1.5, 15.1.8, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2, 43 дугаар зүйлийн 43.3 дахь заалтууд, Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.4.10, 3.6.1, "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.2.3, 4.7.6, Засгийн газрын 278 дугаар тогтоолын 4.8.13, 4.8.29 дэх заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- ✓ Байгууллагын төсвөөс төсвийн тухай хуулийн ном, гарын авлага зэргийг 4,700,000 төгрөгөөр бэлтгэсэн, хүчин төгөлдөр анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэлгүйгээр хөрөнгө зарцуулж, төсвийг үрэлгэн зарцуулсан,
- ✓ Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг санхүүжүүлэхдээ хууль тогтоомж сурталчлах зардалд 3,800,000 төгрөг, сургалт үйл ажиллагааны зардалд 2,500,000.0 төгрөгийг Иргэдийн төлөөлөгчийн хурлын мэргэжилтний дансаар бэлнээр авч анхан шатны баримтын бүрдэлгүйгээр зарцуулсан,
- ✓ Орон нутгийн хөгжлийн сангаас хувь иргэнд анхан шатны баримтгүйгээр 3,491,250 төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон,

8428050570

- ✓ Удирдлага мэдээллийн системийн хэрэгжилт оруулаагүй, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрны их засварын ажлын гүйцэтгэлийн баталгаа гаргуулаагүй, урьдчилгаа санхүүжилтийг 30%-аас их олгосон, гэрээ дүгнээгүй,
- ✓ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нутгийн зөвлөлийн уулзалт зохион байгуулах зардалд 19,000,000 төгрөгийг нярав руу шилжүүлэн, арга хэмжээг зохион байгуулсан хүмүүст хуваарилан зарцуулсан ч зарцуулалтын тайлан, анхан шатны баримтад үндэслэн тооцоо бодоогүй, ОНХС-аас урсгал үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулсан,
- ✓ Үндэсний их баяр наадмаас бусад баяр наадам, тэмцээн уралдааны зардалд 214,747,925 төгрөг зарцуулж, төсвийг үрэлгэн зарцуулсан,
- ✓ Хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт тодорхойгүй хөтөлбөр арга хэмжээнд сангийн хөрөнгийг төлөвлөн зарцуулсан,
- ✓ Тайлант онд эдийн засгийн ангилал зөрчин гүйлгээ хийсэн, эрх бүхий байгууллагаас тогтоосон төлбөрийн актыг төсвөөс төлж гүйлгээ хийсэн, ОНХС-аас Мянган сүтэйн буян ХХК-д урсгал үйл ажиллагааны санхүүжилтэд 130,000,000 төгрөг олгосон бөгөөд уг мөнгөөр тус аж ахуйн нэгж нь худалдан авах ажиллагаа зарлалгүйгээр 2 ширхэг автомашин худалдан авсан байхад дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Цэцэг сум нь 2025 оны байдлаар 3,221 хүн амтай, 854 өрхтэй, 253 малчин өрхтэй, мал бүхий 258 өрхтэй, жилийн эцсийн мал тооллогоор 121,752 толгой мал тоолуулжээ.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Цэцэг сум нь татварын болон татварын бус орлогоор нийт 840,156.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, орлогыг 106,237 мянган төгрөг буюу 11.2 хувиар дутуу бүрдүүлсэн байна. Тайлант онд ангийн тусгай зөвшөөрөл дутуу олгогдсонтой холбоотой ангийн төлбөрийн орлого 62.7 сая төгрөгөөр тасарсан нь сумын татварын орлого дутуу биелэх шалтгаан болжээ.

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татсан асуудлыг дүгнэлтийн үндэслэл хэсэгт тусгасан болно.

#### **Бусад асуудлын хэсэг**

Сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 5 бодлогын хүрээнд 253 арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлж байна.

Сумын Засаг дарга аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хүрээнд нэгдүгээр хавсралтаар 6 зорилтын хүрээнд 55 арга хэмжээ, хоёрдугаар хавсралтаар 5 зорилтын хүрээнд 51 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөн, дэвшүүлсэн зорилт гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Засаг дарга 86.0 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

## **2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

### **2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан**

Мянган төгрөгөөр

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,448,864.68</b>	<b>2,709,994.15</b>
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,520,785.52	1,154,308.11
3	1.1.3 АВЛАГА	1,775,428.38	1,377,884.21
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	101,613.13	102,113.13
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	51,037.65	75,688.7
6	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,609,819.95	8,521,935.06
7	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,609,819.95	8,521,935.06
8	1.2.2.02 Биет хөрөнгө	8,595,125.95	8,507,241.06
9	1.2.2.03 Биет бус хөрөнгө	14,694.0	14,694.0
<b>10</b>	<b>1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>	<b>12,058,684.62</b>	<b>11,231,929.21</b>
<b>11</b>	<b>2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>85,701.76</b>	<b>291,803.27</b>
12	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	85,701.76	291,803.27
13	2.1.1.03 Өглөг	85,701.76	291,803.27
<b>14</b>	<b>2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>11,972,982.86</b>	<b>10,940,125.94</b>
15	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	11,972,982.86	10,940,125.94
16	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал	856,592.57	856,592.57
17	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	10,839,994.91	9,807,137.99
18	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	276,395.37	276,395.37
<b>19</b>	<b>2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>	<b>12,058,684.62</b>	<b>11,231,929.21</b>

### **2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Мянган төгрөгөөр

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>6,657,068.48</b>	<b>3,084,893.16</b>
<b>2</b>	<b>1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>1,032,188.78</b>	<b>810,231.33</b>
<b>3</b>	<b>1.1.1.03.1 Орлогын албан татвар</b>	<b>768,487.54</b>	<b>618,065.62</b>
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар	798,463.24	646,985.72
5	1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-29,975.7	-28,920.09
6	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	32,485.65	42,980.85
7	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	231,215.59	149,184.85
<b>8</b>	<b>1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,667,916.68</b>	<b>2,274,661.83</b>
9	1.1.1.04.2 Хөрөнгийн орлого	41,703.85	8,401.44
10	1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	990,254.74
11	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,956,963.02	0.0
<b>12</b>	<b>1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>5,288,408.79</b>	<b>4,020,161.26</b>

13	<b>1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>5,288,408.79</b>	<b>4,020,161.26</b>
14	<b>1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>5,249,539.79</b>	<b>3,741,268.46</b>
15	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	750,037.85	859,256.12
16	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,231.05	112,244.77
17	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,150,147.9	671,923.78
18	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	1,646,281.58	1,311,339.48
19	1.1.2.01.1.05 Нормативт зардал	6,564.8	0.0
20	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	8,071	13,446.35
21	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	9,010	12,358.1
22	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	64,320.66	119,588.35
23	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	1,520,874.95	641,111.5
24	<b>1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>38,869</b>	<b>278,892.8</b>
25	<b>1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>1,368,659.69</b>	<b>-935,268.11</b>
26	<b>1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>15,150</b>	<b>73,163.63</b>
27	<b>1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)</b>	<b>-15,150</b>	<b>-73,163.63</b>
28	<b>1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)</b>	<b>1,353,509.69</b>	<b>-1,008,431.73</b>

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мянган төгрөгөөр

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	<b>1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>5,867,928.23</b>	<b>3,835,179.68</b>
2	<b>1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>1,032,188.78</b>	<b>810,231.33</b>
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	768,487.54	618,065.62
4	1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-29,975.7	-28,920.09
5	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	32,485.65	42,980.85
6	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	231,215.59	149,184.85
7	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	35,398.7	33,547.52
8	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	93,937.43	16,346.74
9	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	101,879.46	99,290.6
10	<b>1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,878,776.43</b>	<b>3,024,948.36</b>
11	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	1,837,072.57	1,611,257.65
12	1.1.1.1.04.2 Хөрөнгийн орлого	41,703.85	8,401.44
13	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	1,012,008.27
14	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	393,281
15	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,956,963.02	0.0
16	<b>1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,294,575.7</b>	<b>2,718,415.78</b>
17	<b>1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,294,575.7</b>	<b>2,718,415.78</b>

18	<b>1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,255,439.7</b>	<b>2,439,522.98</b>
19	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	816,964.23	871,807.19
20	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	109,675.54	112,529.4
21	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,165,829.26	707,740.09
22	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	46,871.99	360,643.84
23	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	553.7	607.7
24	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	9,110.7	13,555.95
25	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	9,899.4	12,358.1
26	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	108,105.68	164,102.51
27	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	988,429.19	196,178.2
28	<b>1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>39,136</b>	<b>278,892.8</b>
29	<b>1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>2,573,352.53</b>	<b>1,116,763.91</b>
30	<b>1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,237,611.39</b>	<b>1,483,241.32</b>
31	<b>1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,237,611.39</b>	<b>1,483,241.32</b>
32	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	2,237,611.39	1,483,241.32
33	<b>1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-2,237,611.39</b>	<b>-1,483,241.32</b>
34	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	38,992	0.0
35	<b>1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>-38,992</b>	<b>0.0</b>
36	<b>1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>296,749.14</b>	<b>-366,477.41</b>
37	<b>1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>1,224,036.38</b>	<b>1,520,785.52</b>
38	<b>1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>1,520,785.52</b>	<b>1,154,308.11</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Мянган төгрөгөөр

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	<b>1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>10,659,261.15</b>	<b>10,659,261.15</b>
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-39,787.98	-39,787.98
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,619,473.16	10,619,473.16
4	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	1,353,509.69	1,353,509.69
5	<b>1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>11,972,982.86</b>	<b>11,972,982.86</b>
6	<b>1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>11,972,982.86</b>	<b>11,972,982.86</b>
7	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-24,425.19	-24,425.19
8	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	11,948,557.67	11,948,557.67
9	1.7 Тайлант үеийн үр дүн	-1,008,431.73	-1,008,431.73
10	<b>1 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>10,940,125.94</b>	<b>10,940,125.94</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Мянган төгрөгөөр

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>4,660,563.10</b>	<b>3,354,336.14</b>
<b>11</b>	<b>3.1.01.1.1 Татварын орлого</b>	<b>930,788.50</b>	<b>810,231.32</b>
110	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	680,954.70	618,065.61
1100	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	709,874.80	646,985.70
1101	3.1.01.1.1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(28,920.10)	(28,920.09)
113	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	20,984.30	42,980.85
118	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	228,849.50	149,184.86
1180	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	48,400.00	33,547.52
1181	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	17,949.50	16,346.74
1182	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	162,500.00	99,290.60
<b>12</b>	<b>3.1.01.1.2 Татварын бус орлого</b>	<b>3,729,774.60</b>	<b>2,535,703.38</b>
120	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	2,409,734.90	1,215,663.68
122	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	926,758.70	926,758.70
121	Хөрөнгийн орлого	-	8,401.44
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсаны орлого	-	8,401.44
123	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	393,281.00	393,281.00
<b>II</b>	<b>3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>6,102,160.40</b>	<b>3,720,145.45</b>
<b>21</b>	<b>3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,964,709.60</b>	<b>2,128,904.13</b>
210	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,962,676.00	1,850,011.33
2101	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	911,374.60	871,807.18
2102	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	113,921.90	112,529.40
2103	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	686,969.10	667,216.18
2104	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	21,332.40	20,112.08
2105	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	727.40	607.70
2106	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	13,982.80	13,555.95
2107	3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	12,616.90	12,358.10
2108	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	71,510.50	44,333.54
2109	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	130,240.40	107,491.20
213	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,033.60	278,892.80
2131	3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	278,392.80
2132	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	2,033.60	500.00
<b>22</b>	<b>3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>3,987,450.80</b>	<b>1,591,241.32</b>
<b>23</b>	<b>3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>150,000.00</b>	<b>-</b>
8	3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ		
9	3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,441,597.30	365,809.31
7	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	1,441,597.30	365,809.31
4	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,481,608.27
5	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,115,798.96

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Мянган төгрөгөөр

Дансны код	Дансны нэр, төрөл	2024.12.31	2025.12.31
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,437,262.22	193,249.57
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,437,262.22	193,249.57
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	1,437,262.22	193,249.57
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	1,437,262.22	193,249.57
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	1,437,262.22	193,249.57
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,437,262.22	165,137.01
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	1,408,481.86	165,137.01
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,408,481.86	165,137.01
2103	1.1.1.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	491,230.30	
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	300.00	300.00
2108	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	55,827.50	104,930.37
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	861,124.06	59,906.64
213	1.1.1.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-
2132	1.1.1.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	-	-
4	1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	28,780.36	28,112.56
6	1.ХАРИЛЦАХ БОЛОН ХАДГАЛАМЖИЙН ДАНСНЫ ЦЭВЭР ӨӨРЧЛӨЛТ	(28,780.36)	(28,112.56)

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 603,641.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 225,402.6 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup>-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

### Хоршоо хөгжүүлэх сангийн тайланд:

- ✓ Хувь хүмүүст олгосон зээлийн эргэн төлөлт төлөөгүй зээлдэгчид гэрээний дагуу алданги тооцож бүртгээгүй - 7,586.0 мянган төгрөг,
- ✓ Хувь хүмүүст олгосон зээлийн эргэн төлөлтөөс орж ирсэн авлагыг тайлант үеийн үр дүнгээр бүртгэсэн, алдангийн авлагыг тооцоогүй – 8,963.0 мянган төгрөг,

### Орон нутгийн хөгжлийн сангийн тайланд:

- ✓ Мо Эн Ко компаниас авах авлага -194,853.6 мянган төгрөг, зураг төсвийн авлага – 14,000.0 мянган төгрөгийг бүртгээгүй – 208,853.6 мянган төгрөг,

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Аудитаар залруулагдаагүй материаллаг алдааны зөрчил нь тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 23,572.4 мянган төгрөгөөс их, шинж чанарын хувьд материаллаг байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхиуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Аудитаар нийт 378,239.2 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 14,491.3 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт, 233,747.9 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага, 130,000.0 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өглөө.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 3.1 Төлбөрийн акт

#### 3.1.1 Иргэдийн Төлөөлөгчдийн хуралтай холбоотой

**3.1.1.1 Илрүүлэлт:** Байгууллагын төсвөөс төсвийн тухай хуулийн ном, гарын авлага зэргийг 4,700,000 төгрөгөөр бэлтгэсэн, хүчин төгөлдөр анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэлгүйгээр хөрөнгө зарцуулж, төсвийг үрэлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.3-д “хэвлэлийн захиалгын төлбөр”, 12.1.4-д “хуулиар зөвшөөрөөгүй бусад” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

**Шийдвэрлэлт:** Төлбөрийн акт тогтоосон.

**3.1.1.2 Илрүүлэлт:** Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг санхүүжүүлэхдээ хууль тогтоомж сурталчлах зардалд 3,800,000 төгрөг, сургалт үйл ажиллагааны зардалд 2,500,000.0 төгрөгийг Иргэдийн төлөөлөгчийн хурлын мэргэжилтний дансаар бэлнээр авч анхан шатны баримтын бүрдэлгүйгээр зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 3.6.1-д “Төсвийн байгууллага нь Төсвийн тухай хуулийн 35.6-д заасан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Монгол банктай хамтран баталсан журмын дагуу бэлэн мөнгө зарцуулах зориулалттай картын данстай байж болно” 3.6.2-д “Төсвийн байгууллага нь энэ журмын 3.6.1-д заасан картын дансанд зөвхөн төрийн сангийн бүртгэлийн данснаас зөвшөөрөгдсөн төлбөрийг шилжүүлэн авч, зориулалтын дагуу зарцуулна” гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

**Шийдвэрлэлт:** Төлбөрийн акт тогтоосон.

#### 3.1.2 Орон нутгийн хөгжлийн сантай холбоотой

**3.1.2.1 Илрүүлэлт:** Орон нутгийн хөгжлийн сангаас хувь иргэнд анхан шатны баримтгүйгээр 3,491,250 төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5-д “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах”-ыг хориглоно, Сангийн сайдын 86 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.7.6-д “Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал” олгохыг хориглох заалтуудтай тус тус

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

**Шийдвэрлэлт:** Төлбөрийн акт тогтоосон.

### 3.2 Албан шаардлага

**3.2.1 Илрүүлэлт:** Удирдлага мэдээллийн системийн хэрэгжилт оруулаагүй, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрны их засварын ажлын гүйцэтгэлийн баталгаа гаргуулаагүй, урьдчилгаа санхүүжилтийг 30%-аас их олгосон, гэрээ дүгнээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-д “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3-д “Урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргаагүй бол захиалагч урьдчилгаа төлбөр төлөхийг хориглоно”, 42 дугаар зүйлийн 42.1-д “Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана”, 42.2-д “Захиалагч гүйцэтгэлийн баталгааны дүнг тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувиар тогтоож тендер шалгаруулалтын баримт бичигт тусгана”, Засгийн газрын 278 дугаар тогтоолын 4.8.13-д “Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр санхүүжих төсөл, арга хэмжээний урьдчилгаа төлбөрийн нийт хэмжээ нь барилга, байгууламжийн төслийн хувьд гэрээний үнийн дүнгийн 30 хувь хүртэл байх бөгөөд тухайн онд батлагдсан нийт санхүүжилтийн дүнгээс ихгүй байна”, 4.8.29-д “Төсөл, арга хэмжээний эцсийн буюу бүрэн санхүүжилтийн хүсэлтэд гэрээг дүгнэсэн байх бөгөөд энэ журмын 16 дугаар хавсралтад заасан “Гэрээ дүгнэх маягт”-ыг үйлдэж баримт бичгийн иж бүрдэлд эх хувиар хавсаргаж ирүүлнэ”, Орон нутгийн хөгжлийн сангийн журмын 3.2.3-д “Тухайн шатны ИТХ-ын тогтоолоор батлагдсан ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний мэдээллийг ИТХ-аас ЗДТГ-ын албан тушаалтанд өгч, тус албан тушаалтан УМС-д оруулна” гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

**Шийдвэрлэлт:** Зөрчлийг таслан зогсоох, дахин давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгсөн.

**3.2.2 Илрүүлэлт:** Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нутгийн зөвлөлийн уулзалт зохион байгуулах зардалд 19,000,000 төгрөгийг нярав руу шилжүүлэн, арга хэмжээг зохион байгуулсан хүмүүст хуваарилан зарцуулсан ч зарцуулалтын тайлан, анхан шатны баримтад үндэслэн тооцоо бодоогүй, ОНХС-аас урсгал үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-д “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

**Шийдвэрлэлт:** Зөрчлийг таслан зогсоох, дахин давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгсөн.

**3.2.3 Илрүүлэлт:** Үндэсний их баяр наадмаас бусад баяр наадам, тэмцээн уралдааны зардалд 214,747,925 төгрөг зарцуулж, төсвийг үрэлгэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-д “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 4.7.2-д “Үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн ёслолын зардал” хориглоно, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.8-д “Байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах”

гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

**Шийдвэрлэлт:** Зөрчлийг таслан зогсоох, дахин давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгсөн.

### 3.3 Зөвлөмж

#### 3.3.1 Орон нутгийн хөгжлийн сантай холбоотой асуудал

**5.3.1.1 Илрүүлэлт:** Хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт тодорхойгүй хөтөлбөр арга хэмжээнд сангийн хөрөнгийг төлөвлөн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.7-д "төсвийн төлөвлөлтийг дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан хөтөлбөрөөр төлөвлөн, хөтөлбөрийн үр дүн болон гарцыг шалгуур үзүүлэлтийн хамт тодорхойлж баталж, хэрэгжүүлэх", 6.5.5-д "хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дараалал, арга замыг тодорхойлох шийдвэрт олон нийтийн саналыг харгалзан үзэх" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөх, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тодорхой болгож сумын ИТХ-аар батлуулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

#### 3.3.2 Төрийн сан, дотоод хяналттай холбоотой асуудал

**3.3.2.1 Илрүүлэлт:** Тайлант онд эдийн засгийн ангилал зөрчин гүйлгээ хийсэн, эрх бүхий байгууллагаас тогтоосон төлбөрийн актыг төсвөөс төлж гүйлгээ хийхэд төрийн сангийн хяналт тавиагүй /сумын эрүүл мэндийн төвд эдийн засгийн ангилал зөрчсөн, төлбөрийн актыг төсвөөс төлсөн/, ОНХС-аас Мянган сүтэйн буян ХХК-д урсгал үйл ажиллагааны санхүүжилтэд 130,000,000 төгрөг олгосон бөгөөд уг мөнгөөр тус аж ахуйн нэгж нь худалдан авах ажиллагаа зарлалгүйгээр 2 ширхэг автомашин худалдан авсан байхад сумын зүгээс дотоод хяналт хэрэгжүүлээгүй нь Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.4.10-д "Төрийн сан төсвийн байгууллагын төлбөрийн хүсэлтийг төлбөр гүйцэтгэхэд үндэслэх санхүүгийн анхан шатны баримттай тулган, батлагдсан төсвийн зарцуулалтын эрх, хөтөлбөр, зориулалт, арга хэмжээ, эдийн засгийн ангилал, ирүүлсэн мэдээлэлд үндэслэн ажлын 3 өдрийн дотор төлбөрийг гүйцэтгэх ба шаардлага хангаагүй тохиолдолд гүйлгээг буцаана", Засгийн газрын 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 4.1-д "Дотоод хяналт шалгалтыг дараах чиглэлээр зохион байгуулна", 4.1.5-д "өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Төрийн сангийн хяналтыг сайжруулах, хууль журам зөрчсөн гүйлгээг гаргахгүй байх, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэхэд онцгой анхаарах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Хоршоо хөгжүүлэх сан	Хувь хүмүүст олгосон зээлийн эргэн төлөлт төлөөгүй зээлдэгчид гэрээний дагуу алданги тооцож бүртгээгүй.	1	7,586.0	1	7,586.0			1	7,586.0				
Хоршоо хөгжүүлэх сан	Хувь хүмүүст олгосон зээлийн эргэн төлөлтөөс орж ирсэн авлагыг тайлант үеийн үр дүнгээр бүртгэсэн, алдангийн авлагыг тооцоогүй.	1	8,963.0	1	8,963.0			1	8,963.0				
Орон нутгийн хөгжлийн сан	МоЭнКо компаниас авах авлагыг бүртгээгүй – 194,853.6 мянган төгрөг, зураг төсөв – 14,000.0 мянган төгрөг	1	208,853.6	1	208,853.6			1	208,853.6				
<b>ДҮН</b>		<b>3</b>	<b>225,402.6</b>	<b>3</b>	<b>225,402.6</b>			<b>3</b>	<b>225,402.6</b>				

##### 4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:								
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн		
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	Байгууллагын төсвөөс төсвийн тухай хуулийн ном, гарын авлага бэлтгэсэн, анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлэлгүйгээр хөрөнгө зарцуулж, төсвийг үрэлгэн зарцуулсан.	1	4,700.0	1	4,700.0							
	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг санхүүжүүлэхдээ хууль тогтоомж сурталчлах зардалд 3,800,000 төгрөг, сургалт үйл ажиллагааны зардалд 2,500,000.0 төгрөгийг Иргэдийн төлөөлөгчийн хурлын мэргэжилтний дансаар бэлнээр авч анхан шатны баримтын бүрдэлгүйгээр зарцуулсан.	1	6,300.0	1	6,300.0							

Орон нутгийн хөгжлийн сан	Орон нутгийн хөгжлийн сангаас хувь иргэнд анхан шатны баримтгүйгээр 3,491,250 төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон.	1	3,491.3	1	3,491.3						
	Удирдлага мэдээллийн системийн хэрэгжилт оруулаагүй, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрны их засварын ажлын гүйцэтгэлийн баталгаа гаргуулаагүй, урьдчилгаа санхүүжилтийг 30%-аас их олгосон, гэрээ дүгнээгүй.	1	-			1	-				
	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нутгийн зөвлөлийн уулзалт зохион байгуулах зардалд хөрөнгө зарцуулсан, нярав руу шилжүүлэн, арга хэмжээг зохион байгуулсан хүмүүст хуваарилан зарцуулсан ч зарцуулалтын тайлан, анхан шатны баримтад үндэслэн тооцоо бодоогүй, ОНХС-аас урсгал үйл ажиллагаанд хөрөнгө зарцуулсан.	1	19,000.0			1	19,000.0				
	Үндэсний их баяр наадмаас бусад баяр наадам, тэмцээн уралдааны зардалд хөрөнгө зарцуулж, төсвийг үрэлгэн зарцуулсан.	1	214,747.9			1	214,747.9				
	Хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт тодорхойгүй хөтөлбөр арга хэмжээнд сангийн хөрөнгийг төлөвлөн зарцуулсан	1	-					1	-		
Төрийн сан, дотоод хяналт	Тайлант онд эдийн засгийн ангилал зөрчин гүйлгээ хийсэн, эрх бүхий байгууллагаас тогтоосон төлбөрийн актыг төсвөөс төлж гүйлгээ хийхэд төрийн сангийн хяналт тавиагүй, ОНХС-аас Мянган сүтэйн буян ХХК-д урсгал үйл ажиллагааны санхүүжилтэд 130,000,000 төгрөг олгосон бөгөөд уг мөнгөөр тус аж ахуйн нэгж нь худалдан авах ажиллагаа зарлалгүйгээр 2 ширхэг автомашин худалдан авсан байхад сумын зүгээс дотоод хяналт хэрэгжүүлээгүй	1	130,000.0					1	130,000.0		
<b>ДҮН</b>		<b>8</b>	<b>378,239.2</b>	<b>3</b>	<b>14,491.3</b>	<b>3</b>	<b>233,747.9</b>	<b>2</b>	<b>130,000.0</b>		

**5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>		

